

БХЯ

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
ХУРАНДАА Д. ГАНХУЯГ

2020 оны 08 дугаар сарын 19 өдөр

НИЙЛҮҮЛЭГЧ:

"ИХ ШҮҮДЭРГЭНЭ ИМПОРТ" ХХК-НИЙ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н. МӨНГӨНЗАГАС

2020 оны 08 дугаар сарын 19 өдөр

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГТ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ  
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ  
Дугаар № ЭТН-2020/02

Улаанбаатар хот  
Батлан хамгаалах яамны 2020 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 1в/2426 дугаар мэдэгдлийг үндэслэн нэг талаас ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ /цаашид "захиалагч" гэх/, нөгөө талаас "ИХ ШҮҮДЭРГЭНЭ ИМПОРТ" ХХК /цаашид "нийлүүлэгч" гэх/ дараах зүйлийг харилцан тохиролцож, Иргэний хуулийн 243, 264 дүгээр зүйлийн дагуу 2020 оны 08 дугаар сарын 19-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ /цаашид гэрээ гэх/ байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль, тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь БХЯ/202007029 дугаартай тендерт шалгаран Багц№2 "ЕСМО аппарат"-ыг хоёр нэр төрлийн /цаашид "бараа" гэх/ нийт 694,000,000.00 төгрөг /зургаан зуун ерэн дөрвөн сая/-өөр нийлүүлэхээр ирүүлсэн бэлтгэн нийлүүлэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн 694,000,000.00 төгрөгийг энэхүү гэрээний Хавсралт №01 буюу гэрээний тусгай нөхцлийн 3.1-д заасны дагуу санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь Хавсралт №02-т заасан нийлүүлэлтийн хуваарийн дагуу барааг нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно.

- 5.1. БХЯ-ны Тендерийн үнэлгээний хорооны гэрээ байгуулах мэдэгдэл
- 5.2. Гэрээний ерөнхий нөхцөл
- 5.2. Гэрээний тусгай нөхцөл
- 5.3. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь
- 5.4. Гүйцэтгэлийн баталгаа

Гэрээ нь энд дурдсан барааг нийлүүлэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэхүү гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд нийцүүлэн чанар стандартын шаардлага хангасан бараа бэлтгэн нийлүүлэх ба шаардлага хангаагүй тохиолдолд түүнийг арилгах үүрэг, хариуцлагыг хүлээнэ.


7. Захиалагч нь энэхүү гэрээний дагуу чанар стандартад нийцсэн барааг нийлүүлэгчээс хүлээн авч, гэрээнд заасан хэлбэрээр санхүүжилтийг олгох үүрэг хариуцлага хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу цахим шуудан, факсаар харилцана.

**ГЭРЭЭГ ХЯНАСАН:**


БХЯ-НЫ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
ДАРГА  
ХУРАНДАА  Б.БАТ-ЭРДЭНЭ


БХЯ-НЫ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА, МАТЕРИАЛ  
ХЭРЭГСЛИЙН ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
ХУРАНДАА  М.МӨНХБАЯР

БХЯ-НЫ ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН,  
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА, ӨРӨНХИЙ САНХҮҮЧ  
ХУРАНДАА  Д.ГАНБАТ

БХЯ-НЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ХУУЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  Г.ЭНХБОЛД

**ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:**

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН  
ДАРГА-ӨРӨНХИЙ ЭМЧ  
ХУРАНДАА  С.БАТБОЛД

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН  
САНХҮҮГИЙН ДАРГА  
ДЭД ХУРАНДАА  Б.БАТНАСАН

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:  
"ИХ ШҮҮДЭРГЭНЭ ИМПОРТ" ХХК-НИЙ  
ГАДААД ХАРИЛЦААНЫ МЕНЕЖЕР  
Р.БОЛОРЦЭЦЭГ

**ХАЯГ:**

Хаяг: УБ хот, БЗД-ийн 22-р хороо,  
Энх тайвны өргөн чөлөө-51,  
Төрийн сан: 100900014006  
Байгууллагын регистр: 9095764  
Харилцах утас: 11-453419, 99052264

Хаяг: УБ хот, СБД-ийн 1-р хороо, Сөүлийн  
гудамж, Сити плаза 603 тоот  
Банкны нэр: Хаан банк  
Дансны дугаар: 5129023743  
Байгууллагын регистр: 2809893  
Харилцах утас: 99096978, 85120450